

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2022.02.09	Б/09	Дэмжлэг үзүүлэх тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 5/09

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 15 дугаар зүйлийн 15.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын иргэн Ц.Нармандахад 100,000 төгрөг, эмчилгээний тусламж хүссэн Алаг-Эрдэнэ сумын иргэн Б.Отгонзаяад 500,000 төгрөг (Зүрхний гажигтай хагалгаанд орох заалттай), Мөрөн сумын иргэн Ц.Мөнгөнтуяад 300,000 төгрөг (Зүрхний ховдол цоорхой, бамбай булчирхайн өөрчлөлттэй), Хатгал тосгоны иргэн Л.Энхамгаланд 500,000 төгрөг (Тархинд цус харвасан байнгийн асаргаатай), Мөрөн сумын иргэн Г.Баярмагнайд 500,000 төгрөг (Бөөрний архаг дутагдал, түрүү булчирхай хавдартай), Мөрөн сумын иргэн, Хөгжимт драмын театрын ажилтан Б.Оюумаад 2,000,000 төгрөг, нийт 3.900.000 (Гурван сая есөн зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 3.900.000 (Гурван сая есөн зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг хавсран гүйцэтгэгч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН